



# 2019

## ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН



# АГУУЛГА

- 1 Компанийн тухай
- 2 Компанийн засаглал
- 3 Бизнесийн үйл ажиллагаа
- 4 Нийгмийн хариуцлага





# Компанийн тухай





# Компанийн ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсад анхны хувийн хэвшлийн эм гоо сайхны үйлдвэр 1990 онд байгуулагдсан бөгөөд Монос нэрийн дор эмийн ургамал хатаан савлаж, чацарганын тос, алтангагнуурын ханд гэх мэт бүтээгдэхүүнүүд гаргаж байсан нь одоогийн Монос Хүнс компанийн үндэс суурь болсон. Бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж үйл ажиллагаа тэлснээр 2012 оноос албан ёсоор бие даасан компани болон өргөжсөн байна. Өнөөдрийн байдлаар 150 орчим ажилтан албан хаагчтай, 6 брэндийн 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг 6,000 орчим цэгт түгээдэг, олон улсын Чанарын Удирдлагын Тогтолцоо болох ISO 9001:2015, Хүнсний Аюулгүй Байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэлийн салбарт анхдагч, олон нийтэд нээлттэй үндэсний үйлдвэрлэгч хувьцаат компани болоод байна.







### Эрхэм зорилго:

Эрүүл мэндийг дэмжсэн хүнсний бүтээгдэхүүнийг, хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэн, олон улсын стандартаар ҮЙЛДВЭРЛЭГЧ, ЭКСПОРТЛОГЧ, дотоодын зах зээлд ТЭРГҮҮЛЭГЧ компани байна.



### Алсын хараа:

ЭРҮҮЛ мэндийг дэмжсэн ОРГАНИК хүнсний бүтээгдэхүүнийг өдөр тутмын хэрэглээнд хэвшүүлэх



### Үнэт зүйлс:

- Итгэлтэй харилцагч
- Мэдлэг, чадвартай бүтээлч хамт олон
- Эрхэм хэрэглэгч
- Эрүүл, чанартай бүтээгдэхүүн
- Ёс зүйтэй бизнес
- Шинэ санал, санаачлага



# 2019 оны онцлох үйл явдлууд



## Монос Хүнс компани хувьцаат компани боллоо

Монос Хүнс компани нь Монос Группийн түүхэнд анхны олон нийтэд нээлттэй компани болж, 28.3 тэрбум төгрөгөөр үнэлүүлэн компанийнхаа 30 хувийг олон нийтэд арилжиж улмаар 4,000 хувьцаа эзэмшигчтэй Монголын Хөрөнгийн Биржид MFC кодоор бүртгэлтэй хувьцаат компани боллоо.

## ТОП-20 ИНДЕКСТ МОНОС ХҮНС ХК ОРЛОО

Монос Хүнс Компанийн хувьцаа 2019 онд идэвхтэй арилжаалагдсан тул Монголын Хөрөнгийн Биржийн 2020 оны ТОП-20 индекст багтан орсон. Мөн зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр ТОП-30 компанийн нэгээр шалгарлаа.



## Борлуулалтын орлого

2018 онтой харьцуулахад 18 хувийн өсөлттэй байлаа.



## Ажилтнуудын сэтгэл ханамж 7 хувиар өслөө

Нийт ажилтнуудын дунд хийгдсэн компанийн соёлын судалгааны дүн буюу сэтгэл ханамжийн байдал өнгөрсөн оноос 7 хувиар өсөж 4.4 /нийт 5.0 онооноос/ болсон нь компанийн засаглал сайжирч байгааг харууллаа.

2019 оны

## “Үндэсний үйлдвэрлэгч” ENTREPRENEUR шагналын эзнээр тодорлоо



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж буй шилдэг аж ахуй нэгж, байгууллагууд, бизнес эрхлэгчдийг шалгаруулан “ENTREPRENEUR” шагналыг гардуулдаг ба Монос Хүнс ХК “Үндэсний үйлдвэрлэгч-Энтерпренер” компаниар шалгарлаа.



## Монос Хүнс ХК-ийн эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр ашиглалтад ороход бэлэн боллоо

4,000 гаруй хувьцаа эзэмшигчдээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр “Эрүүл Мэндийн Ус Ундааны үйлдвэр”-ийг ашиглалтад оруулахад бэлэн болсон бөгөөд энэхүү үйлдвэр нь нийт 1,700 метр квадрат талбайтай, олон улсын стандартад нийцсэн хамгийн сүүлийн үеийн техник технологиудаар тоноглогдсон бүрэн автомат үйлдвэр гэдгээрээ онцлог юм.



## Монос Хүнс ХК Олон улсын ISO 9001:2015 болон HACCP стандартын батламжаа гардан авлаа

Монос Хүнс ХК нь Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлээ.



## Хан-Уул дүүргийн “Шилдэг шимтгэл төлөгч, ажил олгогч байгууллага”-аар Монос Хүнс ХК тодорлоо

Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2019.06.12-ны өдөр “Ажил олгогчдын зөвлөгөөн” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр Монос Хүнс ХК дүүргийн “Шилдэг шимтгэл төлөгч, ажил олгогч байгууллага”-аар шалгарсан байна.



## “FoodEx Japan 2019” үзэсгэлэнд “Монос Хүнс ХК” оролцлоо

Хүнсний салбарын 44 дэх удаагийн “FoodEx 2019” олон улсын үзэсгэлэн Япон улсын Токио хотод энэ оны гуравдугаар сарын 5-аас 8-ны хооронд зохион байгуулагдлаа. Монос Хүнс ХК тус үзэсгэлэнд 2018 оноос эхлэн Япон улсын зах зээлд гаргаж эхэлсэн гурван нэр төрлийн байгалийн зэрлэг жимстэй “Эко уусдаг цай”-гаар оролцсон юм. Мөн түүнчлэн 2019 оноос шинээр үйлдвэрлэж эхэлсэн Өтгөрүүлсэн барагшүн бүтээгдэхүүнүүдийг танилцууллаа.



## Шилдэг сав баглаа боодолтой бүтээгдэхүүн Энхжин

Энхжин эрүүл мэндийн цуврал цай нь “Улаанбаатар Түншлэл 2019” олон улсын намрын үзэсгэлэн ярмагаас “Шилдэг САВ БАГЛАА БООДОЛТОЙ БҮТЭЭГДЭХҮҮН”-ээр шалгарлаа.



## Хүүхдэд зориулсан шилдэг бүтээгдэхүүн BerryVit

“Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн” уриан дор Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яамнаас зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд 2019” үзэсгэлэн худалдаанд Монос хүнс компани амжилттай оролцож Берривит брэндийн ааруултай үрэл бүтээгдэхүүнээрээ “ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН” шагналыг авлаа.





# Компанийн засаглал



# ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



## **Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч Та бүхний амар мэндийг эрэн мэндчилье.**

Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигч Та бүхэн 2019 оны 5 дугаар сард Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийг барьж байгуулах төсөлд итгэл хүлээлгэн 8.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн билээ. Үүний дагуу бид бүх хүчээ дайчлан ажиллаж Шинэ үйлдвэрээ ашиглалтад оруулахад бэлэн болоод буйг дуулгахад таатай байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, барилгын өргөтгөлийн ажлууд, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хүний нөөцийн бэлтгэл зэрэг их ажлын ард гарч эхний үр дүнгүүдээ хүртэх цаг ийнхүү ирлээ.

Монос Хүнс ХК 2019 онд борлуулалтын өсөлт, ашигт ажиллагаагаа өмнөх онуудын түвшинд хадгалж, асар богино хугацаанд орчин үеийн бүрэн автомат үйлдвэрийн бүтээн байгуулалтыг амжилттайгаар хэрэгжүүлсэн, үйл ажиллагаандаа олон улсын ISO-9001:2015, НАССР стандартуудыг нэвтрүүлэн баталгаажуулсан зэргийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс компанийн үйл ажиллагааг амжилттай хэмээн дүгнэж цэвэр ашгийн 54 хувийг буюу 408 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан. Ингэснээр Монос Хүнс ХК нь үнэт цаасны танилцуулгын үеэр хувьцаат компани болсон эхний жилээс ногдол ашиг хуваарилах амлалтандаа хүрч хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг бүрэн дааж буйн илрэл юм.

Бид ирэх жилүүдэд ашигт ажиллагаа, борлуулалтын орлогоо тогтвортой өсгөх, эрүүл мэндийн шингэн хүнсний салбарт шинэ чиг хандлагыг тодорхойлогч байхыг зорин ажиллах бөгөөд НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд, нийгэм эдийн засагт чиглэсэн олон арван ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Дэлхий нийтийг хамарсан халдварт өвчин гарч эдийн засаг, нийгмийн байдал тодорхой бус байгаа хэдий ч бидний зүгээс бүх хүчээ дайчлан ажиллаж зах зээлд гаргахаар төлөвлөсөн шинэ бүтээгдэхүүнүүдээ хэрэглэгчдийнхээ гарт хүргэх болно.

Бидэнд өндөр итгэл хүлээлгэж хөрөнгө оруулалт хийсэн хувьцаа эзэмшигчдэдээ болон амжилт ололт бүхний ард зүрх сэтгэлээ зориулан ажилладаг Монос Хүнс ХК-ийн удирдлагууд, нийт ажилтнууддаа чин сэтгэлийн талархлаа илэрхийлж эрүүл энхийг хүсэн ерөөе.

Монос Хүнс ХК-ийн ТУЗ-ийн дарга  
**Л. ХҮРЭЛБААТАР**



# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Д.Хүрэлбаатар**

ТУЗ-ийн дарга  
Монос Группийн  
Ерөнхийлөгч



**Х.Ананд**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
Монос Групп ХХК  
Гүйцэтгэх захирал



**Ц.Цэцэгбадам**

ТУЗ-ийн ердийн гишүүн,  
Монос Групп ХХК  
Санхүү эрхэлсэн захирал



**Х.Солонго**

ТУЗ-ийн ердийн гишүүн,  
Монос Косметик ХХК  
ТУЗ-ийн дарга



**А.Отгондарь**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
Монос Хүнс ХК  
Гүйцэтгэх захирал



**Ч.Баттогтох**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
АШУУИС  
Тэнхимийн эрхлэгч



**Ч.Чинзориг**

ТУЗ-ийн хараат бус гишүүн,  
Тандем Глобал ложистик  
Монголиа ХХК  
Гүйцэтгэх захирал



**Б.Долгормаа**

ТУЗ-ийн хараат бус гишүүн,  
Голомт фاینэншил групп ХХК  
Санхүү хариуцсан захирал



**Б.Гантулга**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Ард Лайф ХХК  
Гүйцэтгэх захирал  
Монголын хувьцаат  
компаниудын холбоо  
Ерөнхийлөгч



# “МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2019 ОНЫ ТАЙЛАН

“Монос хүнс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 6 дугаар сарын 26 өдөр хуралдаж, хараат бус 3, ердийн 6, нийт 9 гишүүдийн бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийг байгуулсан.



## ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц:

### Стратеги, бизнес хөгжлийн хороо

- Х.Ананд /хорооны дарга/
- Ч.Чинзориг /гишүүн/
- Б.Гантулга /гишүүн/

### Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

- Х.Солонго /хорооны дарга/
- Ч.Чинзориг /гишүүн/
- Б.Долгормаа /гишүүн/

### Аудитын хороо

- Б.Долгормаа /хорооны дарга/
- Ц.Цэцэгбадам /гишүүн/
- Б.Гантулга /гишүүн/



ТУЗ-ийн 2020.02.18-ны өдрийн ээлжит хурлаар компанийн 2019 оны санхүү болон үйл ажиллагааны тайлан, БДО Аудит ХХК-аас хийсэн хөндлөнгийн аудитын тайлантай танилцаж 2019 оны татварын дараах цэвэр ашгийн 54 хувь буюу 408.8 сая төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ тараах шийдвэрийг гаргалаа.



Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 06 өдрийн 14:00 цагаас Монос Хүнс ХК-ийн Эрүүл мэндийн Ус Ундааны шинэ үйлдвэр дээр зохион байгуулж хөрөнгө оруулалтаар бий болсон бүтээн байгуулалтыг танилцуулахаар шийдвэрлэлээ.




# Бизнесийн үйл ажиллагаа



# 2019 онд хийгдсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажлууд

Эх орны хөрсөнд тарьж ургуулсан Монгол саримсыг ашиглан үйлдвэрлэсэн **ШИДЭТ САРИМС** хэмээх органик шинэ бүтээгдэхүүнийг 2019 онд худалдаанд гаргалаа. Хар саримс нь 33 төрлийн хүхэрт органик нэгдэл, 17 төрлийн амин хүчил, 11 төрлийн эрдэс бодис, 5 төрлийн нүүрс ус, фенолт нэгдлүүдийг тус тус агуулсан байгалийн ховор нандин бүтээгдэхүүн юм. Энэхүү бүтээгдэхүүнийг дархлаа дэмжих, холестерины хэмжээг тогтворжуулах, харшлын шинж тэмдгийг бууруулах, хэт исэлдлээс (антиоксидант) урьдчилан сэргийлэх, хавдар үүсгэгч эсийг дарангуйлах зорилгоор хэрэглэнэ.



**ЭНХЖИН** эрүүл мэндийн цуврал цайг бүрэн шинэчлэн зах зээлд дахин танилцууллаа. Монос Группийн ерөнхийлөгч Л.Хүрэлбаатар болон Эм Судлалын Хүрээлэнгийн эрдэмтдийн судалгаанд үндэслэн бүтээгдсэн ЭНХЖИН эрүүл мэндийн цуврал цай нь биологийн идэвхт ургамлуудаар нэн баялаг бөгөөд тогтмол хэрэглэснээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээний үр дүнг дэмжих үйлчилгээтэй.

**ӨТГӨРҮҮЛСЭН БАРАГШУН** бүтээгдэхүүнийг худалдаанд гаргав. Барагшун нь далайн түвшнээс дээш 2500-4000 метрийн өндөр уул, хаданд олон мянган жилийн турш салж бороо, нарны гэрэл, халуун хүйтэн уур амьсгалын үр дүнд давирхайдан бүрэлдэж тогтсон байгалийн маш ховор биологийн идэвхт түүхий эд бөгөөд өдөр тутам хэрэглэхэд төвөгтэй байдаг тул хэрэглээг хялбаршуулсан савлагаатайгаар хэрэглэгчдийнхээ гарт хүргэж эхэллээ.



# БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

Бид эмийн ургамал, зэрлэг жимс, цагаан идээ зэрэг найдвартай түүхий эдүүдийг Эм Судлалын Хүрээлэнгийн эрдэмтдийн хийсэн судалгаа шинжилгээнд үндэслэн олон улсын дэвшилтэт технологиор боловсруулж хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргадаг. Импортыг орлогч эрүүл мэндийн бэлдмэл – ЦЭНЭГ, Эмийн ургамалтай “Энхжин” эрүүл мэндийн цуврал цай, Монголдоо анхдагч, зэрлэг жимстэй “Эко” уусдаг цай, Хүчил шүлтийг тэнцвэржүүлэгч, эрүүл мэндийн Зөөлөн ус - “Экос”, Багачуудын дуртай ааруул, үзэм, витаминт үрэл – Берривит, Чацаргана жимсний шүүс, тос – “Хаан жимс” гэсэн брэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

## ЭМИЙН УРГАМАЛТАЙ “ЭНХЖИН” ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАЙ

Эмнэх чадвар, биологийн идэвхт үйлдлээрээ үл орлогдох Эмийн ургамлуудыг олон жилийн туршилт судалгааны үндсэн дээр Эм Судлалын Хүрээлэнтэй хамтран хөгжүүлж Инноваци шингэсэн эрүүл мэндийн Энхжин цайны цувралыг эрхэм хэрэглэгчдэдээ хүргэж байна.



Энхжин цайнд орсон ургамал тус бүрийг биологийн идэвхт бодисын агууламж хамгийн өндөр үед нь түүн бэлтгэж, тусгай технологиор боловсруулдаг тул өдөр тутамдаа ууж хэрэглэснээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм. Эмчилгээний үед өөрт тохирох Энхжин цайны төрлийг сонгон хэрэглэснээр эмчилгээний үр дүнд сайнаар нөлөөлж хурдан илааршихад тус болно.





# ЭКОС-ЭРҮҮЛ МЭНДИЙН УС



ЭКОС эрүүл мэндийн ус нь хүний биед нэн хэрэгтэй байгалийн хужраар эрдэсжүүлж, зөөлрүүлсэн, pH 8.5-тай шүлтлэг ус юм. Монголчууд шиг мах ихтэй хүчиллэг хоол хүнс түгээмэл хэрэглэдэг хүмүүст ходоодны хүчил ихэссэнээр цээж хорсох, гол харлах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Энэ үйл явц удаан үргэлжилбэл ходоодны шарх цаашилбал хорт хавдар үүсэх, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо гэмтэх эрсдэлтэй. Тиймээс ходоодны хүчил шүлтийн тэнцвэрт орчныг бүрдүүлэх ач холбогдол бүхий Экос зөөлөн усыг эрхэм хэрэглэгчдэдээ санал болгож байгаа билээ.

# pH 8.5





## ЦЭНЭГ-ЭРҮҮЛ МЭНДИЙН БЭЛДМЭЛ

Өдөр тутмын завгүй амьдралын хэв маягт тохируулан бүтээсэн Цэнэг-Эрүүл мэндийн бэлдмэл нь биологийн идэвхт эмийн ургамлууд болон амин дэм ихтэй жимснүүдийг хандалж, орчин үеийн технологитой хослуулан бүтээсэн шууд уух зориулалттай эрүүл мэндийн бүтээгдэхүүн юм. Цэнэг бэлдмэлийг тогтмол хэрэглэснээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээний үр дүнд сайнаар нөлөөлөх зэрэг онцгой ач холбогдолтой.

## ИМПОРТЫГ ОРЛОХ ҮНДЭСНИЙ БРЭНД, БАЙГАЛИЙН ЗЭРЛЭГ ЖИМС, ҮР ТАРИАТАЙ ЭКО УУСДАГ ЦАЙ

Монголын анхны уусдаг цайны брэнд “Эко уусдаг цай” нь аньс, нэрс, чацаргана жимстэй гэсэн 3 нэр төрөлтэйгээр хэрэглэгчдэд танигдаж байсан бол сулийн гурил, хужир, арвай, шар будаа зэргээр хийцэлсэн Өег сүүтэй цайгаар нэр төрлөө нэмсэн билээ. Уламжлалт сүүтэй цайны амт чанарт нийцүүлэн бүтээсэн энэхүү цайг аялал зугаалга, ажил, оффисын орчинд хэрэглэхэд тохиромжтой бөгөөд алжаал ядаргаа тайлах, дархлаа дэмжиж өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд нэн тустай.





# ХААН ЖИМС-ХАЙРТАЙ БҮХНЭЭ ХАМГИЙН САЙНААР ХАЛАМЖИЛЪЯ

Бид Дархан-Уул аймгийн Бүрэн толгойн үржил шимт хөрсөнд Чацаргана тариалалтын талбайтай бөгөөд хурааж авсан жимсээрээ чацарганын тос, шүүс зэрэг бүтээгдэхүүнийг Хаан Жимс брэндийн дор үйлдвэрлэн эрхэм хэрэглэгчдэдээ хүргэдэг. Үүнээс гадна эх орны хөрсөнд ургасан аньс жимсийг орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчдээс авч Хаан жимс брэндийн өтгөрүүлсэн болон шууд уух шүүс үйлдвэрлэж байна.

В1 А С  
К В2 Е Р  
Витаминууд



## БЕРРИВИТ

Аньс, Нэрс, Чацаргана жимсэнд агуулагдах олон төрлийн аминдэм, эрдэс бодисуудыг хүүхэд багачуудад хүргэх зорилготой зохион бүтээгдсэн Берривит брэндийн Витаминт үрлийн нэр төрлийг жил ирэх тусам баяжуулсаар Үзэмтэй, Ааруултай нэр төрлүүдийг үйлдвэрлэж эхлээд байна. Эдгээр үрлүүд нь Витамин С болон кальциар баялаг бөгөөд хадгалах хугацаа уртасгагч болон бусад химийн нэмэлт бодис агуулаагүйгээрээ онцлогтой.





# ӨТГӨРҮҮЛСЭН БАРАГШУН 80%



Барэгшунг уламжлалт анагаах ухаанд 3000 жилийн өмнөөс хэрэглэж ирсэн бөгөөд 400 гаруй өвчин эмгэгийг анагаах, урьдчилан сэргийлэх үндистай гэж үздэг. Хүний бие махбодод нийт 90 орчим төрлийн эрдэс шаардлагатай байдаг бөгөөд үүнээс 60 орчмыг нь өдөр тутмын хоол хүнсээр дамжуулан авснаар аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм. Барэгшунд Натри, Кали, Кальци, Төмөр, Фосфор, Мангани, зэрэг 30 орчим шимт эрдэс бодис, 6 төрлийн амин хүчлүүд мөн олон төрлийн биологийн идэвхт бодисууд агуулагддаг тул элэг, бөөр, цөс, эд, эсийн нөхөн төлжилтийг эрчимжүүлэх, Ясны хугаралт, бэртэнгийн эдгэрэлтийг түргэсгэх, хүний биеийн эрдэс тэжээлийн хэрэгцээг хангах, дархлаа сайжруулах, зүрх судасны эрхтэн системийн үйл ажиллагааг дэмжих, чихрийн шижин, ходоодны улайлт, шархлаа зэрэг өвчлөл, аливаа харшлын үед үүж хэрэглэснээр эмчилгээг дэмжих, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

## ШИДЭТ САРИМС

Шидэт саримс нь энгийн саримснаас харьцангуй зөөлөн, тааламжтай үнэртэй, чавга шиг амттай. Хар саримсны өөх, тос, уураг, төмөр, цайр, магни, натри зэрэг химийн элементүүд нь энгийн саримснаас 30 дахин их, хөгшрөлтийн эсрэг үйлчлэл нь 11 дахин их байдаг. Полифенол буюу хөгшрөх үйлчилгээг сааруулдаг энэхүү химийн бодис нь энгийн саримснаас 20 дахин илүү байна. Монгол орны хөрсөнд ургасан саримсыг тусгайлан тохируулсан исгэх зууханд, химийн ямар нэгэн нэмэлт бодис холилгүйгээр 30 хонуулахад Шидэт саримс бий болдог. Шидэт саримс нь 33 нэр төрлийн хүхэрт органик нэгдэл, зарим төрлийн энзим, 17 төрлийн амин хүчил, 11 төрлийн эрдэс бодис, 5 төрлийн нүүрс ус, Фенолт нэгдлүүдийг тус тус агуулсан байгаль дэлхий бүтээж, хүний гараар бий болгосон ховор нандин бүтээгдэхүүн юм.

Mg

Fe

Na

Mn

Ca

P


K






# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


## Борлуулалтын орлого /Сая₮/




## Цэвэр ашиг /Сая₮/



## Борлуулалтын цэгийн тоо



## ЕБИТДА /Сая₮/





# ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН /Сая₮/	2019 он төгрөг	2018 он төгрөг
Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого	9,433,040	7,995,754
Борлуулалтын өртөг	(5,204,353)	(4,471,994)
Үнэ цэнийн бууралтын гарз	(51,169)	(9,000)
<b>Нийт ашиг</b>	<b>4,177,518</b>	<b>3,514,760</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	(1,051,438)	(890,420)
Борлуулалт ба маркетингийн зардал	(2,179,453)	(1,527,980)
Үйл ажиллагааны бусад орлого	13,494	8,091
Бусад зардал	(42,443)	(33,405)
Найдваргүй авлагын зардал	-	-
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг</b>	<b>917,678</b>	<b>1,071,046</b>
Санхүүгийн орлого	227,805	13,320
Санхүүгийн зардал	(266,512)	(181,352)
Түрээсийн хүүгийн зардал	(10,355)	-
Бусад олз	-	3,261
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>868,616</b>	<b>906,275</b>
Орлогын албан татварын (зардал)/өгөөж	(106,673)	(95,259)
<b>Тайлант жилийн ашиг</b>	<b>761,943</b>	<b>811,016</b>



*Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу 2018 оны хагас жилээр хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл хийгдэж, элэгдлийн зардал өссөн. Уг дахин үнэлгээтэй холбоотой элэгдлийн зардал нь 2018 онд хагас, 2019 онд бүтэн жилээр тооцогдсон тул 2019 оны цэвэр ашиг 2018 оноос буурсан. Харин EBITDA /Хүү, татвар, элэгдэл хорогдлын зардлаас өмнөх ашиг/ 1,961 сая төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн.*




# САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /Мянга₮/	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Бараа материал	1,600,457	1,747,027
Урьдчилж төлсөн төлбөр	591,714	1,493,680
Худалдааны болон бусад авлага	1,791,610	1,331,293
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,056,219	5,095
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>5,040,000</b>	<b>4,577,094</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Өмч, барилга, тоног төхөөрөмж	13,759,582	7,761,594
Биет бус хөрөнгө	1,990,521	2,426,223
Хөрөнгө ашиглах эрх	172,107	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	37,133	10,710
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>15,959,343</b>	<b>10,198,527</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>20,999,343</b>	<b>14,775,622</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Худалдааны болон бусад өглөг	1,169,073	987,231
Гэрээний өр төлбөр	4,174	15,788
Орлогын татварын өглөг	55,464	112,082
Түрээсийн өр төлбөр-БХ	113,266	-
Зээл болон өр төлбөр	376,270	1,083,954
<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>	<b>1,718,247</b>	<b>2,199,054</b>
Урт хугацаат өр төлбөр		
Түрээсийн өр төлбөр-УХ	65,886	-
Зээл болон өр төлбөр-Урт хугацаат	3,334,346	4,673,846
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>	<b>3,400,232</b>	<b>4,673,846</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>5,118,478</b>	<b>6,872,901</b>
<b>Өмч</b>		
Хувьцаат капитал	2,318,182	1,622,727
Нэмж төлөгдсөн капитал	6,835,733	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	4,102,127	4,908,365
Хуримтлагдсан ашиг	2,624,823	1,371,628
<b>Нийт өмч</b>	<b>15,880,864</b>	<b>7,902,720</b>
<b>Нийт өр төлбөр ба өмч</b>	<b>20,999,343</b>	<b>14,775,622</b>

# ХУВЬЦААНЫ ХАНШИЙН МЭДЭЭЛЭЛ

Монос Хүнс ХК-ийн хувьцаа Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индексэд, зах зээлийн үнэлгээгээр ТОП-30 компанийн жагсаалтад багтлаа. 2019 оны жилийн эцсийн байдлаар компанийн зах зээлийн үнэлгээ 28,7 тэрбум төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг дараах графикаар үзүүлээ.

## Хувьцааны ханшийн өсөлт, бууралт



**72.3**

Хамгийн дээд ханш

**51**

Хамгийн доод ханш

**70.3**

2019 оны нээлтийн ханш

**71.5**

2019 оны хаалтын ханш

**13,852,715**

Арилжаалагдсан ширхэг

**964,504,284**

Арилжааны үнийн дүн

Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж, ТОП-20 индексийн багцыг жилд 1 удаа шинэчлэн тооцоолдог. 2020 оны ТОП-20 индексийг бүрдүүлэгч компаниудыг 2019 оны сүүлд тодорхойлсон бөгөөд хоёрдогч зах зээлд гарснаасаа хойш Монос Хүнс компанийн /MFC/ хувьцаа 13,852,715 сая ширхэг арилжаалагдаж ТОП-20 индексэд багтсан байна.

№	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ХААЛТЫН ХАНШ	ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ
1	TTL	Таван толгой ХК	6,485	341,533,822,000
2	GOV	Говь ХК	262	204,233,452,500
3	APU	АПУ ХК	606	645,362,261,001
4	SUU	Сүү ХК	209	71,896,000,000
5	LEND	ЛэндМН ББСБ ХК	42	33,720,000,000
6	MNP	Монгол шуудан ХК	630	62,739,408,690
7	MBW	Монгол Базальт ХК	250	14,103,685,830
8	AIC	Ард Даатгал ХК	709	17,725,000,000
9	MNDL	Мандал Даатгал ХК	50	31,277,510,160
10	BDS	Би ди сек ХК	900	12,325,394,700
11	AARD	Ард санхүүгийн нэгдэл ХК	1,530	43,779,822,390
12	MIK	Мик холдинг ХК	14,940	309,397,240,800
13	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	635	9,991,217,000
14	ADB	Ард кредит ББСБ ХК	74	20,806,800,000
15	ERDN	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК	564	2,254,080,000
16	INV	Инвескор ББСБ ХК	2,612	187,353,321,816
<b>17</b>	<b>MFC</b>	<b>Монос хүнс ХК</b>	<b>72</b>	<b>29,531,266,414</b>
18	SHG	Шарын гол ХК	1,255	12,763,653,710
19	TUM	Түмэн шувуут ХК	167	33,388,000,000
20	UID	Улсын их дэлгүүр ХК	1,138	41,887,333,300



# КОМПАНИЙН СОЁЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ

Монос Хүнс ХК-ийн нийт ажилтнуудын тоо 2019.12.31-ний байдлаар **144** бөгөөд энэ онд шинээр **36** ажлын байр бий болгосон нь өнгөрсөн онтой харьцуулахад **33** хувиар өссөн байна.

Бид Монгол Улсын Хөдөлмөрийн хууль, Нийгмийн даатгалын хуулиар хөдөлмөр эрхэлж буй бүх эх болон ганц бие эцэг хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй бол хоёр цагийн завсарлага авах эрхтэй бөгөөд үүнийг ажилласан цагт оруулан тооцохыг дэмжин ажилладаг.

Мөн ажил хийх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай иргэдийг дэмжин ажиллаж нийт ажилтны **5** хувийг эзэлж байна.



# 144

Нийт ажилтны тоо



Эрэгтэй ажилтан



Эмэгтэй ажилтан



# 45

Ажилтнуудаа хамруулсан сургалтын тоо



# 112

Сургалтын цаг



# 340

Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо /Давхардсан тоогоор/



# 12

Шинэ ажилтны чиглүүлэх сургалт



## Тайсо дасгалын цаг

Хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, үе мөчний уян хатан байдлыг хадгалахад тустай маш энгийн 3 минутын энэ дасгалыг хамтдаа хийдэг




## Өглөөний цай

Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор Өглөөний цай хөтөлбөр хэрэгжүүлж байна



## Уян хатан цагийн систем

Ажилтнуудын эрх ашгийн үүднээс ажил эхлэх цагийг 3 төрлийн сонголттой болгосон нь ажилтнуудын хувьд хүссэн цагаа сонгох таатай нөхцөл бүрдэж байгаа юм.



## Номын сан

Мөн ажилтнуудын танин мэдэхүйн хэрэгцээг хангах ажилчдын номын санг нээн ажиллуулж байна.



# Нийгэмд үзүүлсэн эерэг нөлөө



# КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Манай компанийн нийгмийн өмнө хүлээж буй хамгийн том үүрэг бол хэрэглэгчдийг олон улсын стандартад нийцсэн эрүүл, чанартай хүнсээр хангахад оршдог. Үүний хажуугаар хэрэглэгчдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өдөр тутмын эрүүл зохистой хүнсний хэрэглээ, амьдралын зөв хэв маягт хэвшүүлэх зорилгоор зорилтот кампанит ажлуудыг авч хэрэгжүүлдэг. Бид 2019 оны хувьд нийгэмд чиглэсэн дараах ажлуудыг амжилттай зохион байгуулаад байна.



## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” өдөрлөг

Мичид ундарга өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” өдөрлөгийг амжилттай зохион байгуулж тус төвийн хүүхэд багачуудтай хамтдаа нэг өдрийг өнгөрүүлээ.



## Улаанбаатар Марафон-2019

Бүх нийтийн биеийн тамир, спортыг дэмжих, эрүүл аж төрөх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилго бүхий олон улсын гүйлтийн тэмцээн болох Улаанбаатар Марафон-2019 арга хэмжээнд Монос Хүнс ХК ивээн тэтгэгчээр оролцож 40 гаруй мянган ард иргэдэд Экос зөөлөн усаараа жил бүр тогтмол үйлчилдэг.



## Эрүүл мэндийн цуврал өдөрлөг

Элэг болон бөөрний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр ард иргэдийн дунд үнэ төлбөргүй цуврал өдөрлөгүүдийг Монос Хүнс компани амжилттай зохион байгуулдаг билээ. 2019 онд уг арга хэмжээнүүдэд нийт 500 гаруй иргэдийг хамруулж эрүүл мэндийн заавар зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн анхан шатны үзлэгт хамруулсан.



## Хүүхдийн баяр

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Өнөр бүл хүүхдийн асрамжийн төв”-ийн хүүхдүүдэд гарын бэлэг гардуулан, хөгжөөнт тоглоом хамтдаа тоглон нэг өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлээ.



### Ахмадуудад зориулсан цуврал сургалтууд

Өвөржанчивлан, Аржанчивлан, Мойлтын тохой, Оргил рашаан сувиллуудад хэвтэн эмчлүүлж байгаа ахмад настнуудад Эрүүл мэндийн цуврал сургалт өдөрлөгүүдийг тогтмол зохион байгуулж өөрсдийн үйлдвэрлэн гаргадаг биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмийн ургамлын ач холбогдлын талаар дэлгэрэнгүй мэдээллүүдийг өгч ажилладаг.



### Таны өгсөн цус 3 хүнд амьдрал бэлэглэнэ

Цус Сэлгэлт Судлалын Үндэсний Төвтэй хамтран жил бүрийн 10 дугаар сард цус бэлэглэх өдөрлөгийг зохион байгуулдаг. Энэ жилийн хувьд “Таны өгсөн цус 3 хүнд амьдрал бэлэглэнэ” уриан доор амжилттай зохион байгууллаа.



### “Monos Care” сайн үйлсийн аян

Ард иргэд хүйтний улиралд халтирч унан гэмтэж бэртэх тохиолдол ихэсдэг тул Монос Хүнс ХК-ийн зүгээс Monos Care аяныг санаачлан ГССҮТ-өөр эмчлүүлж буй зорилтот бүлгийн ард иргэдэд суга таяг үнэ төлбөргүйгээр тараах аяныг зарласан. Тус аянд хувь хүн, албан байгууллагууд сайн дурын үндсэн дээр нэгдсэн бөгөөд аяны хугацаанд 4,5 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний 164 таягийг, гэмтэж бэртсэн 91 хүнд хандивлаж тус хүргэжээ.



### Эмч зөвлөж байна цахим зөвлөгөө


Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор өөрсдийн сошиал сувгуудыг ашиглан мэргэжлийн эмчийн зөвлөгөөг цаг үеийн тулгамдсан асуудлаар тогтмол явуулдаг бөгөөд сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан дохионы хэлийг давхар ашиглаж эхлээд байна.



# КОМПАНИЙН НОГООН БИЗНЕСИЙГ ДЭМЖСЭН АЖИЛ


ДАРХАН УУЛ АЙМАГ

35га-24,000 



Дархан-Уул аймаг дахь Орхон сумын Энхтал 2-р багт тариалангийн 35 га газарт 24,000 гаруй бүт ургуулж жилдээ 20-30 тонн ургац хураан үйлдвэрлэлдээ ашиглаж байна

Ховордож буй ургамлын түүхий эдийн нөөц, генийн санг хадгалах үүднээс Монос Группийн харьяа Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд эмт ургамал тарималжуулалтын талаар судалгаа туршилтуудыг хийдэг.



Үйлдвэрлэлээс гарч буй хог хаягдлыг бууруулах, хэрэглэгчдэд очиж буй бүтээгдэхүүний сав баглаа боодлыг дахин ашиглахуйц байлгахыг зорьдог. Одоогоор бид үйлдвэрлэлээс гарч буй хог хаягдлыг дөрвөн төрөлд ангилан ялгаж цаашид хоёрдогч түүхий эд болгон дахин боловсруулах нөхцөлийг ханган нийлүүлдэг.



Бүтээгдэхүүний сав баглаа боодолдоо хог хаягдлын ангилан хаях олон улсын стандартыг нэвтрүүлж хялбар таслах шугамыг бүтээгдэхүүний шошгондоо ашиглаж эхлээд байна. Ингэснээр ард иргэд өөрийн хэрэглэсэн бүтээгдэхүүний сав баглаа боодлыг ангилан хаяж, хог хаягдлыг менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн.



Үйлдвэрийн хэмжээнд байгальд ээлтэй, эрчим хүчний зарцуулалт багатай LED гэрэлтүүлгүүд, эрчим хүчний хэмнэлт бүхий A+ ангиллын цахилгаан хэрэгслүүдийг ашиглахаас гадна, тоног төхөөрөмжүүдэд инвертор моторыг ашигласнаар цахилгаан эрчим хүчийг 14-20 хувиар бууруулах боломжтой боллоо.



Усны хэрэглээг багасгах, зүй зохистой ашиглалтыг бий болгох үүднээс шинээр ашиглалтад орж буй үйлдвэртээ саарал усыг дахин ашиглах шугам сүлжээний холболтуудыг хийсэн. Төхөөрөмжүүдэд инвертор моторыг ашигласнаар цахилгаан эрчим хүчийг 14-20 хувиар бууруулах боломжтой боллоо.





+976 7773525



Info@monosfoods.mn  
www.monosfoods.mn



Хан-Уул дүүрэг, 2-р хороо,  
17043 Чингисийн өргөн чөлөө  
Улаанбаатар хот, Монгол Улс